

Гуравдугаар зүйл

1. Консулыг татан дуудсан, экзекватур хучингуй болеон буюу консул нас барсан уед консулын уйл ажиллагаа зогсоно.

2. Татан дуудагдах, экзекватур хучингуй болох, консул нас барах болон тур эзгуй байх зэрэг бусад шалтгаанаар консул уйл ажиллагаагаа явуулах бололцоогүй уед туунийг орлогч нь орлох эрхтэйг суугаа орны зохих байгууллагуудад урьдчилан мэдэгдсэн байна.

Консулын уургийг тур гуйцэтгэж байгаа орлогч нь энэ гэрээгээр консулд олгосон бух эрх ямба, хөнгөлөлтийг эдлэнэ.

-П-

Консулын эрх ямба, хөнгөлөлтүүд

Дөрөвдүгээр зүйл

1. Суугаа орон нь консул ба консулын газрын ажилтан нараас албан хэргээ саадгүй явуулахад нь бүрэн бололцоо олгоно. Консул ба консулын газрын ажилтан нараас албан уургээ гуйцэтгэхэд нь бух талын туслалцаа узуулнэ.

2. Консулын газрын албан байранд ул халдана. Консулын албан байр, еөрий нь сууцанд консулын зөвшөөрөлгүйгээр суугаа орны байгууллагуудаас ямар нэг албадах аргыг хэрэглэж ул болно.

3. Консулын архивт ул халдана. Консулын архивт хувийн баримт бичгийг ул хадгална.

4. Албан бичиг хэрэгт ул халдах бөгөөд туунд узлэг хийж ул болно. Энэ нь цахилгаан мэдээ, утсаар ярмх, цахилгаан илгээлт, радио холбоонд нэгэн адил хамаарна.

5. Консул нь томилсон улсынхаа байгууллагуудтай шифрээр харилцах эрхтэйгээс гадна холбоо барих зорилгоор дипломат элчийг хэрэглэж болно. Консул нь ердийн холбооны хэрэгслийг дипломат төлөөлөгчдийн нэгэн адил тарифаар ашиглана.